




СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2019-2023



Улаанбаатар хот 2024 он

Сонгинохайрхан дүүрэг нь 95.8 мянга гаруй өрхийн 341.3 мянган хүн амтай, 27 мянга гаруй аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулдаг томоохон дүүргийн нэг билээ.


2019 онд тус дүүргийн орон нутгийн төсвийн орлого 32916.4 сая төгрөг байсан бол 2023 онд 109201.2 сая төгрөг болж 3.3 дахин өссөн байна. Нийт орон нутгийн төсвийн орлогын 82.8 хувийг татварын орлогоос бүрдүүлсэн байна. Орон нутгийн төсвийн зарлага 2023 онд 93383.7 сая төгрөг байгаа нь 2019 оноос 3.2 дахин өссөн байна. 2023 оны нийт зарлагын 13896.2(14.8%) сая төгрөг нь цалин, урамшуулал, нэмэгдэлийн зардал байна. Энэ нь 2019 оноос 8936.8 сая төгрөг буюу 2.8 дахин нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Орон нутгийн төсвийн орлого, зарлага, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023
Нийт орлого	32 916.4	31 360.1	37 906.1	66 603.6	109 201.2
Татварын орлого	16 106.2	16 877.4	24 775.9	65 421.3	90 520.7
Нийт зарлага	28 715.0				93 383.7
Цалин, урамшуулал, нэмэгдэл	49 59.4				13 896.2

Мэдээллийн эх үүсвэр: СХД-ийн ЗДТГ-ын санхүү төрийн сангийн хэлтэс

Дүрслэл 1. Орон нутгийн төсвийн орлого, сая төгрөг




Сонгинохайрхан дүүрэгт Талх чихэр ХК, Алтан тариа ХХК, Сүү ХК, Мах импекс ХК зэрэг нийслэлийн томоохон хүнсний аж үйлдвэрийн газрууд хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэж хүн амын хүнсний хэрэглээнд нийлүүлж байна. Статистикийн албан ёсны мэдээнд хамрагддаг аж үйлдвэрийн газруудын дүнгээр 2022 онд 1216440.1 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн бол 2023 онд 1717920.3(41.2%) сая төгрөг болж өссөн байна. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт 2022 онд 1517911.7 сая төгрөг байсан бол 2023 онд 2178349.5(43%) сая төгрөг болж өссөн байна.

Хүнсний аж үйлдвэрийн газрууд 2022 онд 696982.9 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн бол 2023 онд 1191996.7 сая төгрөг буюу 71.0 хувиар, хүнсний бус бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2022 онд 519457.2 сая төгрөг болсон бол 2023 онд 525923.6 сая төгрөг буюу 0.01 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 2. Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, борлуулалт сая төгрөгөөр

Үзүүлэлт	Үйлдвэрлэлт			Борлуулалт		
	Бүгд	Хүнсний	Хүнсний бус	Бүгд	Хүнсний	Хүнсний бус
2019	505 431.8	466 971.5	38 460.3	538 500.4	501 140.6	37 359.8
2020	587 033.8	453 358.5	133 675.3	623 231.6	506 113.8	117 117.8
2021	943 764.6	571 942.1	371 822.5	1 183 333.4	521 745.8	661 587.6
2022	1 216 440.1	696 982.9	519 457.2	1 517 911.7	819 758.0	698 153.7
2023	1 717 920.3	1 191 996.7	525 923.6	2 178 349.5	1 505 873.0	672 476.5
<u>2023</u> 2022%	41.2	71.0	0.01	43.5	83.0	-3.6

Дүрслэл 2. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, борлуулалт, тэр бум төгрөгөөр



Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлээс хүнсний гол хэрэглээ болох мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2019 онд 94877.6 сая төгрөг байсан бол 2023 онд 454558.6 сая төгрөг болж 4.7 дахин өссөн бол үр тарианы гурил үйлдвэрлэл 2019 онд 85716 сая төгрөг байсан бол 2023 онд 169188.8 сая төгрөг болж 1.9 дахин нэмэгдсэн байна. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2019 онд 163532.8 сая төгрөг байсан бол 2023 онд 274519.1 сая төгрөг болж 1.6 дахин өссөн байна.

Хүснэгт 3. Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, сая төгрөгөөр

Эдийн засгийн салбар	2019	2020	2021	2022	2023
Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт	94 877.6	85 153.4	110 761.0	121 805.8	454 558.6
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	163 532.8	161 774.3	198 099.6	214 493.2	274 519.1
Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл	85 716.0	95 394.6	101 203.3	122 294.8	169 188.8
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	70 615.3	71 185.2	108 985.6	161 366.9	220 177.9
Архи, ус, ундаа үйлдвэрлэл	52 229.8	39 850.8	52 892.4	77 022.2	73 876.0
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	466 971.5	133 675.3	371 822.5	519 457.2	525 923.6

Хүнсний бүтээгдэхүүний борлуулалт 2019 онд 501140.6 сая төгрөг байсан бол 2023 онд 672476.5 сая төгрөг болж 1.3 дахин өссөн байна. 2023 онд мах махан бүтээгдэхүүний борлуулалт 717428.1 сая төгрөг болсон нь 2019 оноос 7.9 дахин, сүү сүүн бүтээгдэхүүний борлуулалт 295573 сая төгрөг болж 2019 оноос 1.8 дахин тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 4. Хүнсний бүтээгдэхүүний борлуулалт, сая төгрөгөөр

Эдийн засгийн салбар	2019	2020	2021	2022	2023
Маж, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт	89 697.5	86 540.1	118 200.4	147 713.2	717 428.1
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	163 502.1	170 582.6	223 707.9	252 891.9	295 573.0
Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл	88 644.1	113 400.6	117 582.9	124 938.1	147 497.3
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	69 248.7	71 486.5	110 203.1	16 664.5	224 604.6
Архи, ус, ундаа үйлдвэрлэл	90 048.2	64 103.8	91 893.0	127 569.8	120 770.0
Хүнсний бүтээгдэхүүн, архи ус, ундаа үйлдвэрлэл -дүн	501 140.6	117 117.8	521 745.8	698 153.7	672 476.5

Сонгинохайрхан дүүрэгт бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын тоо 2023 онд 27371 болж 2019 оноос 4084(17.5%) –өөр аж ахуйн нэгж, байгууллагаар өсөн нэмэгдсэн байна. 2023 онд бүртгэгдсэн нийт аж ахуйн нэгж байгууллагын 23623(86.3%) нь аж ахуй нэгжүүд, 3748(13.7%) нь төсөвт болон төрийн бус байгууллага байна. 2023 онд хязгаарлагдмал хариуцлагатай компаний тоо 22697 болсон нь 2019 оноос 4659(25.8%) - өөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 5. Аж ахуйн нэгж байгууллагын тоо, төрлөөр

Аж ахуй нэгж, байгууллагын төрөл	2019	2020	2021	2022	2023
Аж ахуйн нэгж, байгууллагын тоо-бүгд	23 287	20 362	22 435	25 865	27 371
ААН-ийн дүн	19 094	17 980	19 758	22 862	23 623
Хувьцаат компани	17	23	39	9	9
Төрийн өмчит үйлдвэрийн газар	13	9	13	15	16
ХХК	18 038	17 212	19 063	21 885	22 697
ЗБН	132	128	105	124	129
ХЗХоршоо	74	74	53	62	97
Хоршоо	128	125	111	334	243
Бусад	692	409	374	433	432
Төсөвт болон төрийн бус байгууллагын дүн	4 193	2 382	2 677	3 003	3 748
Төсөвт байгууллага	201	147	189	181	131
ТББ	2 736	2 403	1 859	2 068	2 229
Бусад	1 256	590	629	754	1 388

Мэдээллийн эх үүсвэр: СХД-ийн татварын хэлтэс


Сонгинохайрхан дүүрэгт хөдөлмөрийн насны хүн амын тоо 2019 онд 227434 байсан бол 2023 онд 228535 болж 1101(0.5%) хүнээр өссөн байна. Ажиллагсдын тоо 2019 онд 105850 байсан бол 2023 онд 116961 болж 11111(10.5%) хүнээр нэмэгдсэн байна. Ажил хайгч иргэдийн тоо 2019 онд 3000 байсан бол 2023 онд 669 болж 2331(77.7%) хүнээр буурсан байна. 2023 онд хөдөлмөрийн насны хүн амын тоо 238.2 болж өмнөх оны мөн үеэс 2.6 (1.1%) мянган хүнээр өссөн байна. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 49.0 болж 2019 оноос 1.3 (2.6%) пунктээр буурсан байна.

Хүснэгт 6. Ажиллагчдын тоо

Үзүүлэлт	Ажиллагчид			Ажилгүй иргэд		
	эр	эм	бүгд	эр	эм	бүгд
2019	55 769	50 081	105 850	12 453	3 788	16 241
2020	61 322	49 128	110 450	3 384	925	4 309
2021	62 951	48 367	111 318	8 149	4 142	12 291
2022	64 773	53 514	118 287	5 556	2 193	7 749
2023	62 586	54 376	116 962	2 445	3 946	6 391

Мэдээллийн эх үүсвэр: ҮСХ-ний ажиллах хүчний судалгааны дүнгээс /2023 оны тоо гараагүй байсан болно

Дүрслэл 3. Ажиллагчидын тоо насны бүлэгээр хувиар



2023 оны нийт ажиллагсадын 62586(53.5%) эрэгтэй, 54376(46.5%) эмэгтэй ажиллагсад байна. Нийт ажилчидыг насны бүлгээр харвал 15-14 насны 465(0.4%), 20-24 насны 8367(7.2%), 25-29 насны 9297(7.9%), 30-34 насны 27884(23.8%), 35-39 насны 19206 (16.4%), 40-44 насны 18745 (16.0%), 45-49 насны 12857 (11.0%), 50-45 насны 10535 (9.0%), 55-59 насны 7282 (6.2%), 60- аас дээш насны 2324 (2.0%) хүмүүс тус тус эзлэж байна. Харин ажилгүй иргэдийн 2445(38.3%) эрэгтэй, 3946(61.7%) нь эмэгтэй байна.

Хүснэгт 7. Ажил хайгч иргэдийн тоо

Үзүүлэлтүүд	2019	2020	2021	2022	2023
Ажил хайгч иргэн /сарын эхэнд/	2 565	1 533	1 287	642	737
Үүнээс: Эмэгтэй	1 331	767	666	333	351
Тайлант хугацаанд нэмэгдсэн иргэн	1 540	439	529	212	3 004
Үүнээс: Эмэгтэй	751	235	301	96	1 520
Тайлант хугацаанд хасагдсан	1 105	702	277	314	2 451
Ажилд зуучлагдан орсон	63	69	171	115	1 261
Ажил хайгч иргэн /сарын эцэст/	3 000	1 270	1 539	540	669
Үүнээс: Эмэгтэй	1 546	653	782	262	307

Мэдээллийн эх үүсвэр: СХД-ийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс

2019 онд ажил хайгч иргэдийн тоо 3000 байгаагаас 1546 (51.5%) нь эмэгтэй байна. 2019 онд 63 иргэн ажилд зуучлагдан орж байсан бол 2023 онд 1261 иргэн ажилд зуучлагдан орсон байна. Ажил хайгч иргэдийн 578(2.6%) нь шилжин суурьшсан, 109(2.9%) нь сургууль төгссөн, 3(0.4%) цэргээс халагдсан, 13(0.5%) нь сургуулиа орхисон, 661(22.0%) нь иргэн цалин орлого хүрэлцэхгүй байгаа, 175(5.8%) нь мэргэжил ур чадвараа ашиглан орлогоо нэмэгдүүлэх, 185(6.2%) нь одоо эрхэлж байгаа ажилаа солих хүсэлтэй, 68(2.3%) нь өрхийн болон хувийн аж ахуй нь орлогогүй болсон шалтгаанаар ажил хайж байгаа иргэд байна.

Хүснэгт 8. Ажилгүйчүүд ажил хайж байгаа зарим шалтгаанаар

Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023
Шилжин суурьшсан	78	23	34	35	578
Сургуулиа орхисон /гарсан, чөлөө авсан/	14	1	4	2	13
Сургууль төгсөөд ажилгүй байгаа	86	17	32	14	109
Гадаадаас эргэж ирсэн	9	-	4	-	4
Цэргээс халагдсан	13	3	2	-	3

Мэдээллийн эх үүсвэр: СХД-ийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс

2023 онд бүртгэгдсэн ажилгүйчүүдийн 8(1.2%) нь тэтгэвэрт гарсан, 108(16.1%) нь орон тооны цомхотголоос, 121(18%) нь эрүүл мэндийн хувьд тэнцэхгүй болсон, 45(6.7%) нь байгууллага татан буугдсан шалтгаанаар ажилгүй болсон байна. Эрүүл мэндийн хувь тэнцэхгүй шалтгаанаар ажилгүй болсон иргэдийн тоо 2019 оноос 99 хүнээр нэмэгдсэн байна. Орон тооны цомхотголын улмаас ажилгүйчүүдийн эгнээнд шилжсэн иргэдийн тоо 2019 оноос 42(63.6%) хүнээр мөн нэмэгдсэн байна.

Хүснэгт 9. Ажилгүйчүүд, зарим шалтгаанаар

Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023
Тэтгэвэрт гарсан	8	3	2	-	8
Орон тооны цомхотголд орсон	66	48	22	18	108
Мэргэжлийн ур чадварын хувьд тэнцэхгүй болсон	2	1	1	3	21
Эрүүл мэндийн хувьд тэнцэхгүй болсон	22	7	1	15	121
Байгууллага татан буугдсан	29	9	15	7	45


Мэдээллийн эх үүсвэр: СХД-ийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс

2023 оны жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллогоор 73824 толгой мал тоологдсон байна. Энэ нь 2019 оноос 3056(4.1%) толгой малаар өссөн байна. Малын тооны өөрчлөлтийг төрлөөр харвал адуу 2023 онд 15838 тоологдсон нь 2019 оноос 8345(111.3%) , үхэр 1198(4.9%) толгойгоор өссөн бол хонь 2051(10.6%), ямаа 4439(22.6%) толгойгоор тус тус цөөрсөн байна.


Хүснэгт 10. Малын тоо, төрлөөр

Он	2019	2020	2021	2022	2023
Бүгд	70 768	80 712	82 358	83 687	73 824
Адуу	7 493	10 492	13 125	13 926	15 838
Үхэр	24 514	24 357	24 248	26 764	25 712
Хонь	19 181	21 739	21 688	20 917	17 130
Ямаа	19 580	24 124	23 286	22 057	15 141

Зураг 4. Малчдын тоо, хүйсээр, оноор



Зураг 5 . Малчдын тоо, насны бүлгээр



Малчдыг насны бүлгээр авч үзвэл 15-34 насны 250(19.0%), 35-59 насны 926(70.5%), 60-аас дээш насны 138(10.5%) насны хүмүүс байна. Нийт малчдын 460 буюу 35.0 хувь нь эмэгтэй малчид байна. Малчдыг насны бүлгээр авч үзвэл 15-34 насны 250(19.0%), 35-59 насны 926(70.5%), 60-аас дээш насны 138(10.5%) насны хүмүүс байна. Нийт малчдын 460 буюу 35.0 хувь нь эмэгтэй малчид байна.

2019 онд нийт 541.5 га талбайд тариалалт хийсэн бөгөөд үүний 62.2(11.5%) га-д төмс, 67.1(12.4%) га-д хүнсний ногоо, 412.2(76.1%) га-д тэжээлийн ургамал тариалсан байна. 2023 онд нийт 1,496.5 га талбайд тариалалт хийснээс 223.8(14.9%) га-д төмс, 179.9 (12%) га-д хүнсний ногоо, тэжээлийн ургамал 1,092.8(73.1%) га-д тариалж байсан байна. 2023 онд төмс, тэжээлийн ургамалын тариалалт болон хүнсний ногоо нэмэгдсэн байна.

Хүснэгт 11.Тариалалтын үзүүлэлт

Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023
Нийт тариалсан талбай	541.5	1 013.3	1 046.9	1 479.3	1 496.5
Төмс	62.2	101	63.4	224.4	223.8
Хүнсний ногоо	67.1	229.4	107.2	140.4	179.9
Ногоон тэжээл	412.2	682.9	876.3	1 114.5	1 092.8

Дүүргийн хэмжээнд 2019 онд 4783 гахай тоолуулж байсан бол 2023 онд 6145 гахай тоолуулж 1362(28.4%) -аар гахайн тоо өссөн байна. 2023 онд тоолуулсан нийт гахайны 5047(82.1%) нь ААНБ д тоологдсон байна. 2023 онд нийт 310071 шувуу тоологдсоноос 309742(99.8%) нь тахиа бол нийт тахианы 308602(99.7%) нь ААНБ-д тоологдож эрс нэмэгдсэн байна.

Хүснэгт 12.Тэжээвэр амьтдын тоо

Төрөл	2019	2020	2021	2022	2023
Гахай	4 783	4 904	5 409	4 772	6 145
Шувуу	581	36 870	148 826	185 480	310 071
Туулай	3	7	21	241	202
Нохой	20 542	20 852	20 836	18 549	15 164
Муур	376	311	405	264	366


Сонгинохайрхан дүүрэг нь 2013 оны байдлаар 43 хороотой бөгөөд 12 хороо нь дан орон сууцны хороод байдаг бөгөөд гэр хороололд зөөврийн ус хэрэглэдэг 66830 өрх байна. Энэ нь 2019 оноос 67 (0.1%)-өрхөөр буурсан байна. Ус түгээх цэгийн тоо 2019 онд 243 байсан бол 2023 онд 44 (18.5%)-цэгээр нэмэгджээ.

Хүснэгт 13. Ус түгээх цэгийн тоо


Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023
Гүний худаг	441	223	439	343	337
Ус түгээх цэгийн тоо	243	226	246	215	288
Зөөврийн ус хэрэглэдэг өрхийн тоо	66 897	67 669	64 108	64 787	66 830

Хонины ястай мах 1 кг нь 2019 онд 3878 төгрөг байсан бол 2023 онд 10200 төгрөг болж 6322(163%) төгрөгөөр, үхрийн ястай мах 1 кг нь 2019 онд 9633 төгрөг байсан бол 2023 онд 13080 төгрөг болж 3447(35.7%) төгрөгөөр, адууны ястай мах 1 кг нь 2019 онд 4250 төгрөг байсан болж 10500 төгрөг болж 6250(147%) дахин, ямааны ястай мах 1 кг нь 2019 онд 3500 төгрөг байсан бол 2023 онд 9000 төгрөг болж 5500(157.1%) төгрөгөөр тус тус өсжээ. Төмс 1 кг нь 2019 онд 754 төгрөг байсан бол 2023 онд 1560 төгрөг болж 806(106.9%) төгрөгөөр, өндөг нэг ширхэг нь 2019 онд 323 төгрөг байсан бол 2023 онд 620 төгрөг болж 297(92%) төгрөгөөр нэмэгдсэн байна.

Дүрслэл 6. Хонины ястай махны үнэ, төгрөгөөр



Дүрслэл 7. Үхрийн ястай махны үнэ, төгрөгөөр



2019 онд Алтан тарианы дээд гурил 1 кг нь 1900 төгрөг байсан бол 2023 онд 3630 төгрөг болж 1730(91%)-төгрөгөөр, Сүү ХК-ны 1 литр сүү 2019 онд 2718 төгрөг байсан бол 2023 онд 4620 төгрөг болж 1902(69.9%) төгрөгөөр, Атар талх 2019 онд 1310 төгрөг байсан бол 2023 онд 2418 төгрөг болж 1108(84.5%) төгрөгөөр, хар талх 2019 онд 1120 төгрөг байсан бол 2023 онд 2767 төгрөг болж 1647(147%) төгрөгөөр, 2019 онд цагаан будаа 1 кг нь 4050 төгрөг байсан бол 2023 онд 4400 төгрөг болж 350(8.6%) төгрөгөөр, 1 кг шар будаа 2019 онд 1900 төгрөг байсан бол 2023 онд 2800 төгрөг болж 900(47.3%) төгрөгөөр, ургамалын тос 1 литр 2019 онд 3476 төгрөг байсан бол 2023 онд 9600 төгрөг болж 6124(176.1%) төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 14 . Хүнсний зарим гол нэрийн бүтээгдэхүүний үнэ

Хүнсний барааны нэр,төрөл	хэмжих нэгж	2019	2020	2021	2022	2023
"Алтан тариа" дээдийн дээд	кг	1 900	2 200	2 200	3 420	3 630
дээд	кг	1 420	1 570	1 577	2 510	2 750
савласан гурил						
1-р зэрэг	кг	1 138	1 300	1 408	2 160	2 400
2-р зэрэг	кг	893	986	1 000	1 460	1 560
Сүү						
Сүү ХК 1л	литр	2 718	2 830	2 950	4 100	4 620
Сүү ХК 0.5л	литр	1 152	1 270	1 400	2 070	2 250
Атар	ширхэг	1 310	1 320	1 500	2 200	2 418
Талх						
Зууван чех	ширхэг	1 600	1 620	2 800	2 810	3 061
Хар талх	300 гр	1 120	1 210	2 100	2 160	2 767
Будаа						
цагаан	кг	4 050	4 050	3 350	3 620	4 400
шар	кг	1 900	2 000	2 500	2 730	2 800
Ургамлын тос,	1 литр	3 476	3 820	9 800	8 860	9 600
Элсэн чихэр	кг	2 943	3 570	5 720	5 720	6 790
Хонины мах ястай	кг	3 878	7 600	8 200	8 200	10 200
Үхрийн мах						
ястай	кг	9 633	9 500	12 100	12 230	13 080
цул	кг	10 323	10 700	13 910	12 600	14 740
Адууны мах, ястай	кг	4 250	9 000	8 610	8 600	10 500
Ямааны мах, ястай	кг	3 500	8 000	7 400	9 000	9 000
Төмс, монгол	кг	754	880	920	1 310	1 560
Лууван, монгол	кг	1 317	1 500	1 520	1 750	2 420
Байцаа, хятад	кг	1 065	1 200	1 400	1 750	1 660
Өндөг, Дотоод	ширхэг	323	360	410	500	620

Барилгын салбарт 2019 онд 161281.1 сая төгрөгийн барилга угсралт их засварын ажил гүйцэтгэсэн бол 2023 онд 188094.5 сая төгрөгийн ажил гүйцэтгэсэн байна. Энэ нь 2019 оноос 26813.4(16.6%) сая төгрөгөөр өссөн байна. 2023 онд 61257 сая төгрөгийн өртөг бүхий орон сууцны барилга баригдсан нь 2019 оноос 45284.1(283.5%) сая төгрөгөөр өссөн байна. Харин орон сууцны бус барилга 2023 онд 95408.5 сая төгрөгөөр баригдсан нь 2019 оноос 7171.9(8.1%) сая төгрөгөөр өссөн байна. 2019 онд инженерийн барилга байгууламжид 51927.9 сая төгрөг зарцуулсан бол 2023 онд 27192.9 сая төгрөг болж 24735.0(47.6%) сая төгрөгөөр өссөн байна. 2019 онд 17968.5 сая төгрөгийн өртөг бүхий цэцэрлэгийн барилга ашиглалтад оруулсан бол 2023 онд 37354.8 сая төгрөгийн өртөг бүхий цэцэрлэгийн барилга ашиглалтанд өгсөн байна. Энэ нь 2019 оноос 14170.0 сая төгрөгөөр буюу 2 дахин нэмэгдсэн байна. Сургуулийн зориулалттай барилгад 2019 онд 13044.2 сая төгрөг зарцуулсан бол 2023 онд 15743.2 сая төгрөг зарцуулсан нь 2699(20.6%) сая төгрөгөөр өссөн байна. 2023 онд эмнэлэгийн зориулалттай барилгад 1775 сая төгрөг зарцуулсан нь 2019 оноос 20405.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 15. Барилга угсралт, их засварын ажил, сая төгрөгөөр

Барилгын төрөл	2019	2020	2021	2022	2023
Орон сууцны барилга /сая.төг/	15 972.9	14 900.4	44 826.0	47 680.1	61 257.0
Орон сууцны бус барилга	88 236.6	68 023.2	28 748.1	38 485.2	95 408.5
Үйлдвэрийн	6 948.3	54.0	-	967.2	-
Худалдаа, үйлчилгээний	350.0	-	-	-	9 650.0
Эмнэлэг	22 180.1	17 863.2	399.1	2 198.2	1 775.0
Цэцэрлэг	17 968.5	6 097.9	3 967.4	14 135.7	37 354.8
Сургууль	13 044.2	28 112.1	13 288.3	10 323.8	15 743.2
Соёлын	3 920.0	4 022.2	5 656.8	2 980.8	-
Спорт, биеийн тамир	3 012.0	1 652.8	242.5	1 242.6	10 542.5
Конторын	6 451.0	5 779.4	2 258.5	2 234.7	8 331.2
Орон сууцны бус бусад барилга	14 361.9	4 441.6	2 935.5	4 402.2	12 011.8
Инженерийн барилга байгууламж	51 927.9	68 442.4	45 371.6	32 356.0	27 192.9
Эрчим хүчний	8 333.3	7 396.8	1 398.1	3 124.4	8 296.9
Хатуу хучилттай авто зам	19 861.9	31 972.7	25 913.9	14 549.5	4 229.7
Далан, суваг, шугам	22 590.1	29 072.9	18 059.6	14 682.1	14 666.3
Их засварын ажил	5 143.7	3 532.5	1 301.1	4 527.7	4 236.1
Нийт	161 281.1	154 898.5	120 246.8	123 049.0	188 094.5

2023 онд дүүргийн нутаг дэвсгэрт 86 шатахуун түгээх цэг байрлаж байна. Энэ нь 2019 оноос 24(38.7%) – цэгээр нэмэгдсэн байна. 2023 онд АИ-95 шатахууны үнэ 1 литр тутамд 3710 төгрөг болсон нь 2020 оноос 1710(85.5%) төгрөгөөр, АИ-92 шатахуун 2023 онд 2390 төгрөг байгаа нь 2019 оноос 640(36.5%) төгрөгөөр, дизелийн түлш 1 литр нь 3890 төгрөг байгаа нь 2019 оноос (65.5%) төгрөгөөр тус тус өссөн байна.

Хүснэгт 16. Шатахууны үнийн өөрчлөлт

Шатахууны төрөл	2019	2020	2021	2022	2023
АИ-95	-	2 000	2 660	3 910	3 710
АИ-92	1 750	1 420	2 130	2 390	2 390
Дизелийн түлш	2 350	2 090	2 776	3 850	3 890
ШТС-ын тоо	62	72	74	77	86


Сонгинохайрхан дүүргийн автомашины тоо 2023 онд 84 850 байгаа нь 2019 оноос 23817 (39%)-оор нэмэгдсэн байна. 2023 оны нийт автомашинаас суудлын авто машин 69628 (82.0%), ачааны автомашин 12674 (15%), автобус 1209 (1.7%), тусгай зориулалтын автомашин 1002 (1.3%) тус тус эзэлж байна.

Хүснэгт 17. Автомашины тоо

Он	2019	2020	2021	2022	2023
Автомашины тоо- бүгд	61 033	64 969	74 144	76 219	84 850
Суудлын	47 614	51 193	59 315	62 107	69 628
Ачааны	11 208	11 422	12 441	11 836	12 674
Автобус	1 209	1 490	1 397	1 329	1 525
Тусгай зориулалтын	1 002	864	991	947	1 023

Мэдээллийн эх үүсвэр: 1212.mn /техникийн хяналтын үзлэгт хамрагдсан авто машины тоо төрлөөр /

Дүрслэл 8. Автомашины тоо, төрлөөр



Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт үйлчилгээ явуулах зөвшөөрөлийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа түргэн үйлчилгээний цэг 2023 онд 151 байгаа нь 2019 оноос 12(9.5%)-оор, согтууруулах ундаа худалдаалдаг дэлгүүр 789 байгаа нь 2019 оноос 73(10.1%)-ээр, түлш, модон материалын худалдааны төв 20 байгаа нь 2019 оноос 13(75.0%)-аар тус тус нэмэгдсэн байна. Дэлгүүрийн тоо 2023 онд 1096 байгаа нь 2019 оноос 179(14%), хүнсний бараа худалдаалдаг дэлгүүр 1019 байгаа нь 2019 оноос 144(12.3%)-аар, бөөний худалдааны төв 15 байгаа нь 2019 оноос 2(8.2%) -оор тус тус буурсан байна.

Хүснэгт 18. Худалдааны төвийн тоо

Үйлчилгээний чиглэл	2019	2020	2021	2022	2023
Худалдааны төв	54	188	169	142	111
Барааны	15	47	31	12	18
Хүнсний	22	91	83	27	35
Түүхий эдийн	1	15	18	55	35
Техникийн	9	8	2	4	3
Түлш модон материалын	7	27	35	44	20
Бөөний худалдааны төв	17	19	19	13	15
ТҮЦ / түргэн үйлчилгээний цэг, мухлаг/ Дэлгүүр	1 275	1 089	1 124	1 137	1 096
Хүнсний биш барааны дэлгүүр	56	61	67	67	73
Хүнсний барааны дэлгүүр	1 163	1 028	1 056	1 070	1 019
Супермаркет	78	65	59	130	74
Согтууруулах ундаа худ/даг хүнсний дэлгүүр	716	722	757	715	789
Согтууруулах ундаа худ/гүй хүнсний дэлгүүр	369	241	240	225	156
Номын дэлгүүр	-	-	1	-	4

Хүснэгт 19. Гэр ахуйн барааны засвар үйлчилгээний газрын тоо

Үйлчилгээний чиглэл	2019	2020	2021	2022	2023	
Гэр ахуйн барааны засвар үйлчилгээ	315	302	290	379	317	Гэр ахуйн барааны засвар үйлчилгээ
Хувцас засвар захиалга	81	84	80	100	66	эрхэлдэг газрын тоо
Цахилгаан хэрэгсэл засвар	9	8	6	11	10	2023 онд 317 болж
Гутал засвар	33	33	33	30	28	2(0.6%)-аар нэмэгдсэн
Модон эдлэл засвар	21	20	16	15	6	байна. Үүнээс
Автомашин болон дугуй засварын газар	138	141	139	198	185	автомашин болон
Алт, мөнгөний дархны газар	6	6	7	8	4	дугуй засвар 185

байгаа нь 2019 оноос 47(34.0%)-оор, цахилгаан хэрэгслэлийн засварын газар 2023 онд 10 байгаа нь 2019 оноос 1(11.1%)-аар нэмэгдсэн байна. Харин хувцас засвар захиалгын газар 2023 онд 66 байгаа нь 2019 оноос 15(18.5%)-аар, алт мөнгөний дархан 2023 онд 4 байгаа нь 2019 оноос 2(33.3%) -аар тус тус цөөрсөн байна.

2023 онд ахуйн үйлчилгээ эрхэлдэг газрын тоо 443 байгаа нь 2019 оноос 38(7.9%)-аар буурсан байна. Үүнээс халуун усны үйлчилгээ эрхэлдэг газрын тоо 59 байгаа нь 2019 оноос 11(15.7%)-ээр буурсан байна. Үсчин 2023 онд 179 байгаа нь 2019 оноос 13(7.8%)-аар нэмэгджээ. 2023 онд барьцаалан зээлдүүлэх үйлчилгээний газар 74 байгаа нь 2019 оноос 41(35.6%)-ээр буурсан байна.

Хүснэгт 20. Ахуйн үйлчилгээний газрын тоо


Үйлчилгээний чиглэл	2019	2020	2021	2022	2023
Ахуйн үйлчилгээ	481	446	459	522	443
Халуун ус	70	70	70	70	59
Саун	4	6	12	7	8
Үсчин	166	152	140	198	179
Гоосайхан	35	67	97	66	54
Зурагчин	34	38	31	24	17
Хими цэвэрлэгээ, угаалга	21	28	29	24	22
Ломбард	115	85	80	78	74

Нийтийн хоолны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 275 үйлчилгээний газар байгаа нь 2019 оноос 18(6.1%)-оор цөөрсөн байна. 2023 онд 2019 оноос зоогийн газар 9(16.3%)-оор, кафе 15(36.5%)-аар буурсан бол цайны газар 14(10.6%)-оор, баар 8(12.3%)-аар тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 21. Нийтийн хоолны газрын тоо, оноор

Үйлчилгээний чиглэл	2019	2020	2021	2022	2023
Нийтийн хоол	293	292	288	330	275
Зоогийн газар	55	53	53	81	46
Цайны газар / гуанз /	132	146	162	170	146
Баар	65	56	47	57	57
Кафе	41	37	26	22	26

Дүрслэл 9. Нийтийн хоолны газрын тоо төрлөөр, оноор



Сонгинохайрхан дүүрэгт хүнсний жижиг дунд үйлдвэрийн тоо 146 байгаа нь 2019 оноос 60(69.7%)-аар, мах махан бүтээгдэхүүний үйлдвэр 57 байгаа нь 2019 оноос 26(83.8%)-аар нэмэгдсэн бол талх нарийн боовны үйлдвэр 18 байгаа нь 2019 оноос 5(21.7%)-аар цөөрсөн байна.

Хүснэгт 22. Хүнсний жижиг, дунд үйлдвэрийн тоо

Үйлчилгээний чиглэл	2019	2020	2021	2022	2023
Хүнсний жижиг, дунд үйлдвэр	86	146	142	165	146
Маж, махан бүтээгдэхүүн	31	56	51	70	57
Гурил	6	11	19	14	19
Талх, нарийн боов	23	41	34	26	18
Сүү, сүүн бүтээгдэхүүн	8	15	18	19	22
Зайрмаг	6	5	4	7	5
Ундаа	2	2	2	5	1
Архи	3	8	6	6	4
Пиво	1	2	2	1	3
Бусад / чихэр, гоймон, квас гэх мэт /	6	6	6	17	17

Сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын тоо 2023 онд 41 байгаа нь 2019 оноос 4(8.8%)-оор буурсан байна. Үүнээс 13 нь жолооны сургалт явуулдаг бөгөөд 2019 оноос 8(38%)-аар буурсан байна.

Хүснэгт 23. Сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын тоо

Үйлчилгээний чиглэл	2019	2020	2021	2022	2023
Сургалт	45	56	56	55	41
Жолоо	21	24	27	22	13
Оёдол	3	5	3	2	4
Гоо сайхан	-	8	8	9	1
Үсчин	-	12	11	11	3
Засварин	15	5	3	-	-
Тогооч, нарийн боов	-	1	2	-	-
Гадаад хэлний сургалт	6	1	2	2	3

ХЯНАСАН:

Б.Баатарцогт Сонгинохайрхан дүүргийн
Статистикийн хэлтсийн дарга

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:

Д.Цэрэнбат Сонгинохайрхан дүүргийн
Статистикийн хэлтсийн мэргэжилтэн

